



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3.2, Засгийн газрын 2017 оны “Төлөвлөгөө батлах тухай” 114 дүгээр тогтоолын 3-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Захиргаа удирдлагын газарт ирүүлж байхыг бүх газар, нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын албаны дарга /Т.Жамбаажамц/- д даалгасугай.

ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



Санхүүгийн зохицуулах хорооны даргын
2022 оны 06 дугаар сарын 23-ны
өдрийн 74 дугаар тушаалын хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх газар, нэгжүүд
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилоонд улс төрийн нөлөөллөөс ангил, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр						
1	4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох	2022	Дүгнэлтүүд нээлттэй, ил тод болсон байх	-	ЗУГ, МТХ
2		Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох	2022	Нөөцийн жагсаалт, бүртгэл ил тод, нээлттэй болсон байх	-	ЗУГ, МТХ
3	4.1.1.2. нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх	2022	Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг шинэчилсэн байх	-	ЗУГ, ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ

4	4.1.1.9. төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах	Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох	2022	Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох ажлын гүйцэтгэл үр дүнд хүрсэн байх	-	БҮХ ГАЗАР, НЭГЖ, МТХ
5	4.1.1.10. Нийтийн албаны сургалтыг байнга зохион байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах /УИХ-ын харьяа байгууллагын албан хаагчдыг сургах/	2022	Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан хаагчдын 90 хувийг сургалтад хамруулсан байх	-	ЗУГ, БҮХ ГАЗАР, НЭГЖ
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр						
6	4.1.2.1. төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	2022	Төрийн үйлчилгээний нэгдсэн үйлчилгээний портал сайтыг боловсронгуй болгосон байх	-	БҮХ ГАЗАР, НЭГЖ, МТХ
7	4.1.2.4. эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	2022	Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулдаг болсон байх	-	ХШЗГ, УХХЗҮЭЗГ, ЗЭСХГ, ДАХ
8	4.1.2.7. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх /зохицуулалтын байгууллагуудаар салбарын үйл ажиллагааг үнэлүүлэх/	2022	Хөндлөнгийн байгууллагаар жил тутамд үнэлгээ хийлгэсэн байх	-	ҮЦГ, ДГ, ББСБГ ХЗХГ, ХШЗГ, УХХЗҮЭЗГ
Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр						
9	4.1.3.5. банк, санхүүгийн байгууллагын санхүү, зээлийн болдогыг боловсронгуй болгож, давуу байдлаа ашиглан иргэн, аж ахуйн нэгжид	Хөрөнгийн эх үүсвэрийг үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх замаар бий болгоход чиглэсэн арга хэмжээ авах /СЯ, Монгол банктэй хамтрах/	2022	Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх бодитой арга хэмжээ авсан байх	-	ББСБГ, ҮЦГ, ДГ, ХЗХГ, ХШЗГ

	хүндрэл учруулдаг байдлыг таслан зогсоох							
10	4.1.3.8.Аудитын үйл ажиллагааг хараат бус, хуулийн дагуу гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэх, шаардлагатай зарим тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гадаад улсын аудитын хуулийн этгээдийг ажиллуулах эрх зүйн орчныг бий болгох	Аудитын байгууллагын ажиллах тэгш нөхцөлийг хангах	2022	Аудитын байгууллагын талаар олон нийтэд хүртээмжтэй мэдээлдэг болсон байх	-			ҮЦГ, ДГ, ХШЗГ
Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр								
11	4.1.10.1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах	2022	Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ ахисан байна.	-			ЗУГ

-----000-----